



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, Засгийн газрын 2009 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд бүрдүүлэх, түүний зарцуулах журмын 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


Нэг. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжих төсөл, хөтөлбөрийн нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртгийг нэгдүгээр, Төслийн хүрээнд худалдан авах үйл ажиллагааны баримт бичгийг бэлтгэх, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах эрх, үүрэг бүхий Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хорооны дарга /Ч.Цогтгэрэл/ - д даалгасугай.

Гурав. Худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга /Ш.Очирхүү/ - д үүрэг болгосугай.

Дөрөв. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Н.Мягмарсүрэн/ - д даалгасугай.


ДАРГА



Б.ЧИНБАТ

0001417

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 23 - ний өдрийн 44 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ

| № | Нэр, төрөл | Төсөл, хөтөлбөрийн нэрс | Төсөвт өртөг |
|---|------------------------|---|---------------|
| 1 | Үүрэн холбоо | Хөдөө орон нутгийн алслагдсан бүс нутагт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх /12 цэгт/ | 1,000,000,000 |
| 2 | Интернэт | Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх /66 сум/ | 210,000,000 |
| 3 | | Өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбогдоогүй сумдыг интернэтжүүлэх /4 сум/ | 210,000,000 |
| 4 | Шуудан | Шуудангийн салбарын үйлчилгээний хүргэлтийн давтамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх /12 аймаг/ | 180,000,000 |
| 5 | Тоон телевиз | Тоон телевизийн үйлчилгээний тасралтгүй байнгын ажиллагаа, чанар, хамрах хүрээг сайжруулах /100 сум, суурин газар/ | 250,000,000 |
| 6 | Судалгаа, Сурталчилгаа | Монгол Улсын үндэсний хиймэл дагуулын сүлжээг хөгжүүлж, харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээг бүх орон даяар хүргэх боломжийг бүрдүүлэх, бодлогын суурь судалгаа | 74,000,000 |
| 7 | | Ярианы синтез (TTS), автомат яриа таних (ASR) судалгааны ажлыг Монгол хэлний хувьд гүйцэтгэж нийт иргэдийн өргөн хэрэглээнд нэвтрүүлэх судалгаа | 45,000,000 |
| 8 | | Иргэдэд харилцаа холбоо, мэдээллийн технологийн талаарх гарын авлага болон сурталчилгааны материал боловсруулж, хэвлэн түгээх | 25,000,000 |

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны 05 дугаар сарын 02 - ний өдрийн 02 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

УХА0531
5202965
1116127529

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний хорооны дарга:

Ч.Цогтгэрэл

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны дарга

Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга:

Ш.Очирхүү

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны ахлах мэргэжилтэн

Үнэлгээний хорооны гишүүд:

Д.Батбаяр

Харилцаа Холбоо, Шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга

Т.Халиунаа

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны нягтлан бодогч

Н.Пүрэвзул

Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн ажлын албаны мэргэжилтэн

Б.Болормаа

Хүний хөгжил, судалгаа, сургалтын төв ТББ-ын гишүүн

П.Батбилэг

Тунамал Эв ТББ-ын гишүүн